

АЖЛЫН ДААЛГАВАР

Төслийн нэр	Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл, IDA credit-P174116
Байршил	Монгол Улс, Улаанбаатар
Ажлын даалгаврын нэр	МУ-д албан эдийн засагт шилжих шилжилтийг дэмжих бодлогын стратеги боловсруулах зөвлөх үйлчилгээ
Үйлчилгээний нэр	Дотоодын зөвлөх хуулийн этгээд – Албан эдийн засагт шилжилтийн цогц бодлогын стратеги, арга хэмжээний төлөвлөгөө, замын зураглал боловсруулах
Гэрээний төрөл	Зөвлөх үйлчилгээ
Хэлний мэдлэг:	Монгол, Англи хэл
Гэрээний хугацаа:	6 сар

ҮНДЭСЛЭЛ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ) нь Дэлхийн банкны Олон Улсын хөгжлийн ассоциацийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр ‘Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл’ (ОБҮДХЭТ)-ийг хөдөлмөрийн зах зээл дэх боломжийг ажил хайгч болон бичил бизнес эрхлэгчдэд хүртээмжтэй хүргэх, онцгой байдлын үед шаардлага хангасан ажиллагчдад түр хугацааны дэмжлэг үзүүлэх зорилгоор хэрэгжүүлж байна.

Төсөл нь дараах 4 бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ:

- 1) Одоогийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний тогтолцоог цогц байдлаар шинэчлэн ажил хайгч болон ажил олгогч нарт “үйлчлүүлэгч-төвтэй” үйлчилгээг хувийн зуучлалын байгууллагуудтай хамтран хүртээмжтэй хүргэх;
- 2) Сонгогдсон хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй хөтөлбөрүүдийн дизайн, хамаарал ба эрэлтэд нийцсэн байдлыг бэхжүүлэх;
- 3) Хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, дүн шинжилгээний чанар, хүртээмжийг сайжруулснаар байгууллага болон хувь харилцагчид мэдээлэлтэй шийдвэр гаргахад нь туслах, төслийн менежмент, хяналт шинжилгээ, үнэлгээнд дэмжлэг үзүүлэх,
- 4) Бизнес эрхлэгчид болон ажилтнуудад цар тахлын үзүүлсэн сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор зохих шалгуур хангасан ажиллагчид болон ажил олгогчдод богино хугацааны тэтгэмж олгох бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ.

Төслийн бүрэлдэхүүн хэсэг 3-ын хүрээнд хэрэгжүүлэх гол зорилтуудын нэг нь Монгол Улс дах албан бус салбараас албан эдийн засагт шилжилтийг хэрэгжүүлэх бодлогын стратеги болон арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах ажил байгаа болно. Энэ ажил нь МУ-ын Тогтвортой хөгжлийн зорилтын 8.3, “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын 3.3 зорилтууд болон ХНХЯ-ны албан бусаас албан эдийн засагт шилжих бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулна.

Дэлхийн банкнаас 2021 оны Ажиллах хүчний судалгаанд үндэслэн гаргасан тооцоо¹гоор албан бус хөдөлмөр эрхлэлтийн нийт хөдөлмөр эрхлэлтэд эзлэх хувь 2021 оны байдлаар 21.4 хувьтай байна. Албан бус хөдөлмөр эрхлэлт нь худалдаа (26 хувь), барилга (20 хувь) болон үйлдвэрлэл, тээврийн салбарт (тус бүрт бараг 15 хувь) их түгээмэл байна. ХАА-н албан бус үйл ажиллагааг оруулан тооцвол албан бус хөдөлмөр эрхлэлтийн нийт эдийн засагт эзлэх хувь 41.2 хувьтай байна.

Түүнчлэн албан бус хөдөлмөр эрхлэлтийн 86 гаруй хувь нь албан бус салбарт байгаа бөгөөд албан бус ажиллагчдын 13 орчим хувь нь албан салбарын компаниудад ажиллаж байна. Монгол Улсад албан бус хөдөлмөр эрхлэлтийн хувь маш өндөр байгаа тул энэ асуудалд онцгой анхаарах хэрэгтэй байна.

Иймд ХНХЯ албан эдийн засагт шилжилтийг хэрэгжүүлэх бодлогын стратеги, арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, гол оролцогч талуудтай хамтран хэрэгжүүлэх саналтай байгаа юм. Энэхүү ажлын даалгавар нь албан эдийн засагт шилжилтийг хэрэгжүүлэх бодлогын стратеги, арг хэмжээний

¹ МУ-ын Хөдөлмөрийн зах зээлийн дүн шинжилгээний тайлан, ДБ, 2022, хуудас 32

төлөвлөгөө, замын зураглалыг боловсруулах зөвлөх байгууллагын гүйцэтгэх ажлын цар хүрээ болон нийлүүлэх бүтээгдэхүүнийг тодорхойлно.

ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

Ажлын хүрээ:

Зөвлөх байгууллага нь одоогийн хэрэгжиж байгаа хууль эрх зүй, бодлогын тогтолцоонд дүн шинжилгээ хийж, албан эдийн засагт шилжилтийн бодлогын стратеги, үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө, замын зураглалыг боловсруулна.

Гүйцэтгэх ажлууд: Зөвлөх байгууллага нь дараах ажлуудыг гүйцэтгэнэ:

- 1) МУ дах албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаарх статистик мэдээлэл болон бусад судалгааны үр дүнг судалсны үндсэн дээр дүн шинжилгээ хийх, үнэлэх; статистик дүн шинжилгээний тайланд дараах үзүүлэлтийг тусгасан байна:
 - Албан бус хөдөлмөр эрхлэлтийн статистик тоон үзүүлэлтүүд (албан бус хөдөлмөр эрхлэлтийн нийт хөдөлмөр эрхлэлтэд эзлэх хувь, ХАА-н болон бусад салбарт эзлэх хувь, эзлэх хувь хүйсээр, насаар, боловсролын түвшнээр, байршлаар, хөдөлмөр эрхлэлтийн төлөвөөр (хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажил олгогч, ажилтан), эдийн засгийн салбараар, ажил мэргэжлээр, хөдөлмөрийн нөхцлөөр (ажлын цаг, орлого г.м));
 - Албан бус хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдал, шалтгаан, ялгаатай бүлгүүдэд тулгарч буй гол асуудлууд, (хөдөлмөр эрхлэлтийн төлөвөөр, хүйс, нас, байршлаар г.м), тэдний ялгаатай хэрэгцээ шаардлагууд;
 - Албан бус бизнесийн үйл ажиллагаа, хөдөлмөрийн харилцааг албажуулахад ялгаатай бүлгүүдэд тулгарч буй саад бэрхшээлүүд.
- 2) Албан бус байдал болон албан шилжилтэд нөлөөлөх татварын бодлого, бизнесийн дүрэм журам, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих бодлого, хөдөлмөр, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын бодлогууд болон бусад холбогдох бодлогуудыг судалж, дүн шинжилгээ хийх;
- 3) Албажуулахыг дэмжих эсвэл хязгаарлах хуулийн зүйл заалт, журам, захиргааны процедур, хууль мөрдүүлэх, хянах механизм, бизнесийн дүрэм журмыг судлах, үнэлж дүгнэх; албан болох, албан хэвээр байхад гарах зардлын тооцоолол гаргах; албажуулах зохицуулалтын тогтолцоог сайжруулах, уялдуулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлох;
- 4) Албан бус байдлыг шийдвэрлэх, албан эдийн засагт шилжилтийг дэмжих татварын бодлого, бизнесийн дүрэм журам, нийгмийн даатгал болон захиргааны процедур зэрэг олон улсын сайн туршлагыг судлах;
- 5) Ярилцлага, фокус бүлгийн уулзалт зохион байгуулах; албан бус ажилтнууд, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн бүлгүүд (залуучууд, эмэгтэйчүүд зэрэг бүлгийг оруулах ба эдгээр бүлгээр хязгаарлагдахгүй) болон ажил олгогчдын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ шаардлагыг тодорхойлох;
- 6) Холбогдох бодлогын чиглэлээр бодлогын стратегийг тодорхойлох. Үүнд дараах чиглэлээрх бодлогын өөрчлөлт болон санал санаачилгыг багтаах боловч үүгээр хязгаарлагдахгүй:
 - Татварын болон нийгийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ;
 - Татвар болон нийгмийн даатгал төлөх процедур, төлбөрийн систем;
 - Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа болон албан бус ажил олгогчдыг албажуулах;
 - Төрийн үйлчилгээ, хөтөлбөр, үр чадварын сургалт, жижиг зээл, төрийн худалдан авалтын хүртээмжийг нэмэгдүүлэх;
 - Албан бус ажилтныг ажилд авах, албажуулсан ажил олгогчид олгох урамшуулал;
 - Хууль мөрдүүлэх стратегиуд;
 - Ойлголт дээшлүүлэх компани ажлууд г.м.
- 7) Үндэсний, салбарын, бүсийн зэрэг цогц бодлогын хүрээнд албанд шилжихийг дэмжих нарийвчилсан арга хэмжээний төлөвлөгөө болон хэрэгжүүлэх замын зураглал боловсруулах;
- 8) Бодлого боловсруулагчид болон хэрэгжүүлэгчидтэй бодлогын стратеги, арга хэмжээний төлөвлөгөө ба замын зураглалыг хэлэлцэх зөвлөлдөх уулзалт зохион байгуулах; үр дүнтэй

зохицуулалт ба хамтын ажиллагааны механизм бүхий байгууллагын удирдлага, зохион байгуулалтыг тодорхойлох;

9) Нэгтгэл тайланг бүх холбогдох оролцогч талуудад түгээх.

Стратеги төлөвлөгөөг боловсруулахад 2015 онд ОУХБ-аас гишүүн орнуудад зөвлөмж болгосон Албан бус салбараас албан эдийн засагт шилжих шилжилтийн зөвлөмж, зааварчилгааг анхаарч үзнэ.

Зөвлөх байгууллага нь i) статистик дүн шинжилгээ зэргийг багтаасан судалгааны тайлан, баримт бичгийн үнэлгээ, ii) бодлого боловсруулагчид болон хэрэгжүүлэгч нартай хийх ярилцлага, iii) албан бус ажиллагчдаас авах санал асуулга болон/эсвэл фокус бүлгийн ярилцлага зэрэг аргачлалыг ашиглана.

Дараах судалгааны тайлан болон бусад холбогдох материалыг судалгаанд ашиглана:

- 1) Ажиллах хүчний судалгаа (ҮСХ)
- 2) Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн төлөв байдал (ОУХБ, ХНХСҮСИ)
<https://www.social-protection.org/gimi/Course.action?id=3>
- 3) Албан бус эдийн засагт ажиллагчдын нийгмийн хамгааллыг өргөжүүлэх (ОУХБ)
https://www.ilo.org/beijing/what-we-do/publications/WCMS_834558/lang--en/index.htm
- 4) Сүүдрийн эдийн засгийн судалгаа ба тооцоолол, 2015-2018 (ҮСХ)
http://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=NOE_2015-2018.pdf&ln=Mn.

Нийлүүлэх бүтээгдэхүүн:

Зөвлөх байгууллага нь дараах бүтээгдэхүүнийг нийлүүлнэ:

Бүтээгдэхүүн 1. 2024 оны 01 дүгээр сарын 31-ний дотор:

- 1.1. Статистик дүн шинжилгээний тайлан, уг тайлангийн слайд (PowerPoint) танилцуулгын хамт;
- 1.2. Хууль эрх зүйн орчин болон бодлогын шинжилгээний тайлан, слайд (PowerPoint) танилцуулга;

Бүтээгдэхүүн 2. 2024 оны 03 дугаар сарын 31-ний дотор:

- 2.1. Олон улсын сайн туршлагын тойм;
- 2.2. Албан бус ажиллагчидтай хийсэн ярилцлага болон фокус бүлгийн хэлэлцүүлгийн тайлан;
- 2.3. Бодлогын стратегиуд; дээр дурдсан бүтээгдэхүүнүүдийн слайд (PowerPoint) танилцуулга;

Бүтээгдэхүүн 3. 2024 оны 05 дугаар сарын 31-ний дотор:

- 3.1. Арга хэмжээний төлөвлөгөө ба хэрэгжүүлэх замын зураглал;
- 3.2. Бодлогын стратегиуд, арга хэмжээний төлөвлөгөө ба замын зураглалыг багтаасан эцсийн нэгтгэл тайлан (ХНХЯ-аар хянуулан, санал зөвлөмжийг тусгаж, эцэслэсэн байна);
- 3.3. Зөвлөлдөх уулзалт ба үр дүнг танилцуулах семинарын тайлан, дээрх бүтээгдэхүүнүүдийн слайд (PowerPoint) танилцуулга.

Гэрээний хугацаа:

Зөвлөх байгууллага нь уг ажлыг нийт ажлын 6 сарын хугацаанд буюу 2023.12.01-ээс 2024.05.31-ний хооронд гүйцэтгэнэ.

Гэрээний үнэ:

Гэрээний үнийн дүн нь зөвлөх байгууллагатай тохиролцсон тогтсон дүн байна. Гэрээний нийт үнийн дүн 160,000,000 хүртэл төгрөг байх бөгөөд ажлын даалгаварт заасан ажлуудыг гүйцэтгэхэд шаардагдах бүх зардлууд багтсан байна.

Энэ ажлын даалгаварт заасан аль нэгэн бүтээгдэхүүнийг үндэслэлтэй нөхцөл байдлын улмаас гэрээ дуусгавар болохоос өмнө нийлүүлж амжаагүй бөгөөд үүнээс шалтгаалж гэрээний хугацааг сунгах тохиолдолд зөвлөх байгууллага нэмэлт зардалгүйгээр бүтээгдэхүүнийг нийлүүлнэ.

Мониторинг, явцын хяналт, тайлагналтад тавигдах шаардлагууд:

Зөвлөх байгууллага нь дээр дурдсан ажлыг ХНХЯ болон ОБҮДХЭТ-ийн ТХН-ийн удирдамж, хяналтын дор гүйцэтгэнэ. Зөвлөх байгууллага нь гэрээт ажлын явцад Дэлхийн банкнаас гэрээлэн техникийн дэмжлэг үзүүлж байгаа олон улсын зөвлөхтэй нягт хамтран ажиллана.

Зөвлөх байгууллагын ажлын гүйцэтгэлийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

- 1) Ажлын даалгаварт тусгасан ажлуудыг бүрэн гүйцэтгэсэн байдал;
- 2) Төлөвлөсөн ажлуудаа хугацаанд нь хэрэгжүүлсэн байдал (олон улсын зөвлөхийн бүтээгдэхүүнтэй бас хамааралтай);
- 3) Гүйцэтгэсэн ажлын чанар.

Тайлагналт:

Зөвлөх байгууллага нь ХНХЯ болон ОБУДХЭТ ТХН-д ажлаа тайлагнаж ажиллана. Зөвлөх байгууллага нь гэрээний төлбөрийн хуваарьт заасан төлбөр авахын өмнө ХНХЯ болон ТХН-д Бүтээгдэхүүн хүлээж авах маягыг бөглөж ирүүлнэ.

Төлбөрийн хуваарь:

Гэрээний үнийн дүн нь энд заасан хугацааг сунгасан эсэхийг үл харгалзан үр дүнд суурилсан тогтсон дүн байна. Гэрээний төлбөрийг дараах хуваарийн дагуу төлнө:

Бүтээгдэхүүн	Төлбөр
Бүтээгдэхүүн 1.1 ба 1.2	Зөвлөх үйлчилгээний ажлын хөлсний 30%
Бүтээгдэхүүн 2.1; 2.2 ба 2.3	Зөвлөх үйлчилгээний ажлын хөлсний 30%, үүн дээр нэмж хэлэлцүүлэг ба орон нутгийн тээврийн зардал
Бүтээгдэхүүн 3.1; 3.2 ба 3.3	Зөвлөх үйлчилгээний ажлын хөлсний 40%, үүн дээр нэмж зөвлөлдөх уулзалт ба үр дүнг танилцуулах семинарын зардал

Зөвлөх байгууллагын нийлүүлсэн бүтээгдэхүүнийг ХНХЯ/ТХН хүлээн авсны дараа төлбөрийг олгоно. Хэлэлцүүлэг, зөвлөлдөх уулзалт, үр дүнг танилцуулах семинарын зардал болон тээврийн зардлыг баримтад үндэслэн нөхөж төлнө.

ШААРДЛАГАТАЙ УР ЧАДВАР, АЖЛЫН ТУРШЛАГА

Зөвлөх байгууллагын багийн бүрэлдэхүүнд багийн ахлагч, бодлогын шинжээч болон хуулийн зөвлөх байна. Багийн ахлах болон мэргэжилтнүүд тухайн зөвлөх байгууллагын үндсэн ажилтан эсхүл түүнтэй тогтвортой хамтран ажилладаг байвал зохино.

Зөвлөх байгууллагын ахлах болон мэргэжилтнүүд дараах шаардлагыг хангасан байна:

Боловсрол:

- Багийн ахлагч нь эдийн засаг, хөдөлмөрийн эдийн засаг, нийгмийн бодлого, төрийн удирдлага болон бусад холбогдох салбарын Докторын зэрэг цолтой байх (эсхүл холбогдох ажлын туршлагатай мастерын зэрэг цолтой);
- Багийн гишүүд эдийн засаг, хөдөлмөрийн эдийн засаг, нийгмийн бодлого, төрийн удирдлага болон бусад холбогдох салбарын мастер болон түүнээс дээш зэрэг цолтой байх;

Туршлага:

- Багийн ахлагч нь хөдөлмөр эрхлэлт эсхүл нийгмийн салбарт бодлого тодорхойлох, бодлогын зохицуулалт, стратеги төлөвлөлт хийх, замын зураглал бэлтгэх чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай;
- Бодлогын шинжээч нь хөдөлмөр эрхлэлт, нийгмийн бодлогын судалгааны дүн шинжилгээ, судалгааны тайлангийн хэлэлцүүлэг, хөдөлмөрийн зах зээл, нийгмийн бодлого төлөвлөлт, шинэчлэлийн ажилд ажиллаж байсан 3-аас доошгүй жилийн туршлагатай;
- Хуулийн мэргэжилтэн нь нийгмийн болон хөдөлмөрийн хууль тогтоомж, дүрэм журам, аргачлал ба зардлын тооцоолол, салбар хоорондын бодлогын зохицуулалтын стратеги боловсруулалтын ажил хийж байсан 3-аас доошгүй жилийн туршлагатай;
- Өмнө нь Дэлхийн банк болон бусад олон улсын донор байгууллагуудтай хамтран ажиллаж байсан туршлагатай бол давуу тал болно;

Ур чадвар:

- Зөвлөх баг хууль эрх зүйн болон бодлогын судалгаа, дүн шинжилгээ ба стратеги хөгжүүлэлт хийх мэдлэг, ур чадвартай;
- Харилцааны өндөр ур чадвартай, зохион байгуулалттай;
- Англи хэлний ярианы болон бичгийн өндөр түвшний мэдлэгтэй;
- Багаар ажиллах, асуудлыг цогцоор зохицуулах ур чадвартай.